

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ ДҮГНЭЛТ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (UPR - UNIVERSAL PERIODIC REVIEW)
МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

«ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАЛТ - ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ»

Хүний эрхийн ТББ-уудын Форумын 2010 оны Нэгдсэн илтгэлд Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөрт хүний эрхийн талаас дүн шинжилгээ хийх, бодлого, хөтөлбөрийг хүний эрхэд суурилсан арга зүйгээр боловсруулах, төлөвлөх, бүх түвшинд хэрэгжүүлэх чадавхи бүрдүүлэх, хүний эрхийн үндэсний бүтэц, механизмыг оновчтой бүрдүүлэн бэхжүүлэх, иргэний нийгмийн бие даасан, тогтвортой үйл ажиллагааг дэмжих сан байгуулахад техникийн туслалцаа авахыг онцлон зөвлөсөн. Зарим зөвлөмжийн

хэрэгжилтэд тодорхой ахиц гарч хэд хэдэн олон улсын гэрээ конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан буюу нэгдэн орох бэлтгэл ажил хийгдэж байна. Дотоодын хууль тогтоомжийн шинэчлэл явагдаж байгаа ч эдгээр үйл явцад олон нийт, иргэний нийгмийн оролцоо хязгаарлагдмал, олон нийтэд сурталчлан таниулах ажил хангалтгүй байна. Түүнчлэн хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах асуудал орхигдсон хэвээр бөгөөд тэднийг дарамтлан шахах явдал ажиглагдсаар байгаа нь харамсалтай.

ШИНЭЭР ГАРГАЖ ТАВИХ АСУУДЛУУД:

1. Монгол улсын хөгжлийн зорилго, зорилтууд, стратегийг тодорхойлж боловсруулахад иргэдийн оролцоог хангах эрх зүйн орчинг бүрдүүлэх, иргэдийн хөгжих эрхийг хангах шаардлага нэн тулгамдаж байна. Учир нь улс орны эдийн засаг бүхэлдээ уул уурхайд тулгуурлаж, ашигт малтмалын зах зээлийн эрэлт, борлуулалтын үнээс иргэдийн амьдрал шууд хамаарах болж, байнгын өндөр инфляци, төгрөгийн ханшны доройтлоос хүмүүсийн худалдан авах чадвар буурч, амьжиргааны түвшин доройтож байна.
2. Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах үндэсний тогтолцоо төлөвшин бүрдээгүй байна. Үүнд:
 - Хүний эрхийн үндэсний комиссын (цаашид Комисс гэх) үйл ажиллагааг Парисын зарчимд нийцүүлэх тухай Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Олон улсын зохицуулах хорооны зөвлөмж биелсэнгүй, Комисс нь хүний эрхийн ноцтой хэрэг дээр бие даасан байр сууриа илэрхийлэх, хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд хүний эрхийн үүднээс дүгнэлт өгөх, шүүмжлэх, засч залруулах зөвлөмж өгөх чадавхиа төдийлөн бүрдүүлж чадаагүй байна.
 - Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын албыг татан буулгасантай холбоотой 2012 оноос хойш хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл байхгүй байна.
 - “Иргэний нийгмийн байгууллагуудын тогтвортой үйл ажиллагааг хангах эрх зүйн орчин, санхүүгийн дэмжлэг байхгүйгээс иргэний нийгмийн зарим байгууллага өөрийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлж чадахгүйд хүрч байна.
 - “УИХ-ын Хүний эрхийн дэд хороог бие даасан хороо болгож, хуулийн төсөл, Улсын Их Хурлаас соёрхон батлах, нэгдэн орох олон улсын гэрээ, конвенцид хүний эрхийн үүднээс дүгнэлт гаргаж чуулганд оруулдаг, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийдэг болгох зэргээр эрхийг нь өргөтгөнө” гэсэн заалт “хоосон тунхаглал” болон үлдэв.

3. Хууль сахиулах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог баталгаажуулах нь эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийгдэж буй томоохон өөрчлөлтийн нэг хэсэг билээ. Шинээр батлагдсан Цагдаагийн албаны тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд иргэний оролцоотой холбоотой зохицуулалт тусгасан ч зарим заалтыг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.
4. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах механизмыг бэхжүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчин бий болгох шаардлагатай байна. Хүний эрхийн асуудлаар төрөөс гаргах хөрөнгө нөөц дутагдалтай байгаагийн зэрэгцээ хүний эрхийг хамгаалах одоогийн хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байна.

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. Олон улсын гэрээ конвенц, Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, эрх зүйн орчинг бүрдүүлэхийн тулд:
 - Шинээр нэгдэн орсон хүний эрхийн гэрээний албан орчуулгыг хийж, олон нийтэд хүртээмжтэй мэдээлэх, шүүхэд хэрэглэх мэдлэг чадавхи, нөхцөлийг бүрдүүлэх.
 - Хүний эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа ТББ-ын тухай хууль, Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах тухай хууль, Иргэдийн оролцооны эрхийг хангах тухай хууль, Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакцийн хараат бус байдлыг хангах тухай хуулийг батлах, мөн УИХ-ын гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх, нийтийн эрх ашгийг нэхэмжлэх, хуулийн хэрэгжилтийн хяналтанд иргэний нийгмийн оролцоог хангах зэрэг зохицуулалтыг зарим хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулах,
2. Хүний эрхийг хамгаалах үндэсний бүтэц, механизмыг бэхжүүлэхийн тулд:
 - Хүний эрх, эрх чөлөөг хангаж, хамгаалах олон улсын гэрээ конвенц, Үндсэн хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хороо идэвхтэй ажиллаж, тус дэд хорооны Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоомж, хөгжлийн баримт бичиг, аливаа шийдвэрт хүний эрхийн дүгнэлт хийх чадавхийг бэхжүүлэх.
 - Хүний эрхийн үндэсний комиссын хараат бус, бие даан ажиллах чадавхийг бүрдүүлж, хүний эрхийг хамгаалах бүрэн эрхийг өргөжүүлэх зорилгоор тус комиссын хуулийг Парисын зарчимд нийцүүлэн шинэчлэн боловсруулах.
 - Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд олон талын оролцоог хангаж, санхүүжилтийг хүрэлцэхүйц болгож, хяналтын механизмыг ажиллуулахад иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулах.
3. Хүний хөгжих эрхэд Монгол Улсын Засгийн газар онцгойлон анхаарч, хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хүний эрхэд суурилсан арга барилаар боловсруулах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх чадавхиа бүрдүүлж, бэхжүүлэх, төрийн албан тушаалтнуудын хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах үүргээ биелүүлэхэд шаардлагатай сургалт зохион байгуулах, хүний эрхийг агуулагч гэдэг ойлголтыг иргэдэд төлөвшүүлж, эрхээ нэхэмжлэх чадамжтай болгох.
4. Хүний эрхэд суурилсан хөгжлийн бодлого тодорхойлох, хөтөлбөрийг төлөвлөх аргачлалд суралцах, бодлого, хөтөлбөр, хуулийн агуулга, хэрэгжилтэд хүний эрхийн дүгнэлт хийх чадавхи бий болгох техник, санхүүгийн туслалцааг олон улсын байгууллагаас авах.

ЭРҮҮДЭН ШҮҮХ БОЛОН БУСАД ХЭЛБЭРЭЭР ХЭРЦГИЙ, ХҮНЛЭГ БУСААР БУЮУ ХҮНИЙ НЭР ТӨРИЙГ ДОРМЖЛОН ХАРЬЦАЖ ШИЙТГЭХИЙН ЭСРЭГ КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгээс «Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц» (ЭШЭК)-ийн хэрэгжилтийн талаар (14), цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын II нэмэлт Протоколыг соёрхон батлах тухай (17), Хүчээр сураггүй болгохын эсрэг конвенцид нэгдэн орох тухай (2) зөвлөмжийг тус тус хүлээн авч,

хэрэгжүүлэх үүрэг амлалтыг авсан юм. Монгол Улсын Их Хурал цаазаар авах ялыг халах тухай Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын II нэмэлт протоколыг 2012 онд соёрхон баталсан. Монгол Улсын Засгийн газар ЭШЭК-ийн Нэмэлт протокол, Хүнийг хүчээр сураггүй алга болгохын эсрэг олон улсын конвенцийг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2014 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн бариад байгаа ч одоогоор соёрхон батлаагүй байна.

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Эрүүдэн шүүх гэмт хэргийг мөрдөн шалгадаг хараат бус, бие даасан албыг татан буулгасан нь Монголын Засгийн газар олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүрэг амлалтаасаа ухарсан үйлдэл хэмээн дүгнэж байна.

Аливаа хэлбэрээр саатуулагдсан этгээд гадаад ертөнцтэй харьцаатай байх, өмгөөлөгчтэйгээ саадгүй уулзах эрхийг хязгаарлах нь хүний эрхийн ноцтой зөрчил юм.

Хоригдож буй этгээдийг байнга оршин суудаг газраас (45км-230км зайд) хол, харьяалал өөр цагдан хорих байранд байлгах, эсхүл цагдан хорих байруудаар дамжуулан хорих, сэтгэл зүйн дарамтанд оруулах үзэгдэл байсаар байна. Энэ нь эрүүдэн шүүлтийн нэг хэлбэр байж болох юм.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурал 2014 оны 1-р сард баталсан 22-р тогтоолоор Улсын Ерөнхий Прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах албыг татан буулгасан.

Авлигатай тэмцэх газар 2014.7.29-ний шөнө сэжигтэн Т нарыг Төв аймгийн цагдан хорих газарт хорисон байна. Авлигатай тэмцэх газрын дарга, эрхэлсэн комиссар Ө.Э нь “Т нарын 3 сэжигтний өмгөөлөгчийн гэрээ нь ирээгүй тул өмгөөлөгч нарыг уулзуулахгүй байхыг мэдэгдье” гэсэн албан бичгийг (2014.7.31-ний өдрийн 06/6444 тоот) хорих газрын удирдлагад илгээжээ.

Төрийн эсрэг гэмт хэрэгт холбогдуулан шалгаж байсан сэжигтнүүдийг Улаанбаатар хотоос шилжүүлэн Дархан-Уул (230км), Төв (45км), Сэлэнгэ аймгийн Зүүнхараа сум (220км)-нд байрлах хорих ангиудад тарааж хорисон.

Хууль сахиулах байгууллага болон бусад төрийн албан хаагч нарыг эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургах сургалтын хөтөлбөр, төсөв байхгүй байна.

Хуульчдын давтан сургалтын хөтөлбөрт эрүүдэн шүүх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөр байхгүй. Эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах яамдад ч мөн энэ чиглэлээр сургалтын хөтөлбөр байхгүй байна.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулж буй Гэмт хэргийн тухай хуулийн төсөл, Гэмт хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд зодож шийтгэхийн эсрэг заалтыг томъёолж оруулсан ч энэ чиглэлээр эрх зүйн орчин бүрдээгүй хэвээр байна.

Гэрийн даалгавар дутуу хийсэн, өөрийн үгээр байсангүй гэх зэрэг шалтгаанаар 2013-2014 онуудад 1 нас 6 сартайгаас 9 настай хүүхдүүдийг зодож шийтгэсэн 5 тохиолдол бүртгэгдсэн ч багш нар зохих хариуцлага хүлээгээгүй байна.

ЭШЭК-ийн 3.1 дэх хэсэгт заасан “Эрүүдэн шүүх аюул тулгарна гэж үзэх хангалттай үндэслэл байвал оролцогч улс уг этгээдийг өөр улсад албадан гаргах, буцаах буюу шилжүүлэн өгөхгүй” байх үүргээ Монгол Улс хэрэгжүүлэхгүй байна.

НҮБ-ын орогногчийн сертификаттай бөгөөд Монгол Улсад оршин суух хугацаа нь 2014 оны 6-р сарын 16-нд дуусах байсан БНХАУ-ын иргэн Н.Тулгуур, мөн оюутны хүчинтэй визтэй, НҮБ-д жилийн өмнө орогнол хүссэн өргөдөл гаргасан байсан Д.Далайбаатар нарыг 2014 оны 5-р сарын 13-нд БНХАУ руу нууцаар гаргасан. Тэд БНХАУ-ын иргэн бөгөөд монгол үндэстэн байжээ.

Дотоодын эрүүгийн хуулиас цаазаар авах ялыг халах шаардлагатай алхмуудыг авч хэрэгжүүлэх үүргээ биелүүлээгүй байна.

Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулж буй Гэмт хэргийн тухай хуулийн төслөөс цаазаар авах ялыг халсан хэдий ч одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд цаазаар авах ял байсаар байна.

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. Эрүүдэн шүүх хэргийг мөрдөн шалгах бие даасан, хараат бус албыг дахин байгуулах.
2. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх үндэсний механизмыг нэн даруй байгуулах.
3. Эрүүдэн шүүхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль сахиулах байгууллага болон бусад холбогдох байгууллагад чиглэсэн үр дүнтэй сургалтын хөтөлбөр баталж, хэрэгжүүлэхэд хүрэлцэхүйц төсөв батлах.
4. Зодож шийтгэхийг хориглосон, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг нэн даруй бүрдүүлэх.
5. ЭШЭК-ийн 3.1-р заалтыг нэг мөр хэрэгжүүлэх.
6. ЭШЭК-ийн 22 дугаар зүйлийг зарлан тунхаглах.
7. Хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулиас цаазаар авах ялыг халах.

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ ДҮГНЭЛТ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (UPR - UNIVERSAL PERIODIC REVIEW)
МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ



Монгол Улс 1974 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИУТЭОУП)-ыг соёрхон баталж, үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөг Үндсэн Хууль, бусад хууль тогтоомжоор баталгаажуулсан хэдий ч иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хараат бус, чөлөөт хэвлэлтэй байх эрх чөлөө зөрчигдсөөр байна. 2010 онд илтгэл явуулснаас хойш улс төр, эрх зүй, зохицуулалтын нөхцөл байдлаас иргэдийн үзэл бодолтой байх эрх, илэрхийлэх эрх чөлөөний асуудал түгшүүр дагуулах болж, ялангуяа Засгийн газраас цахим эрх чөлөөг

хязгаарлах алхмууд хийгдэж эхэлсэн, түүнчлэн улс төрч, албан тушаалтнууд Эрүүгийн хуулийн нэр төр гутаахтай холбоотой 110, 111-р зүйлийг хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эсрэг ашиглах нь нэмэгдэж буй нь энэ илтгэлийг бичих үндэслэл болов. Монгол Улсад шүгэлдэгчийг, сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах хууль болон өргөн нэвтрүүлгийн тухай зэрэг тусдаа хууль байхгүй. Засгийн Газраас санаачлан УИХ-д өргөн барьсан «Гэмт хэргийн тухай» хуулийн төсөлд нэр төр гутаахыг эрүүгийн хэргээс халсан бөгөөд одоогоор хэлэлцэж батлаагүй байна.

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Агуулгын зохицуулалтыг хуулиар тогтоосон ч хяналтыг төрийн байгууллагууд хийдэг нь цензур болон ашиглагдаж байна.

Үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөнд тавих хязгаарлалтыг зөвхөн хуулиар тогтоох ёстой ч зохицуулах байгууллагын гаргасан, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй, хүчин төгөлдөр бус дүрэм, журмаар хязгаарлалт тогтоож байгаа нь цензур болон ашиглагдаж байна.

Цахим эрх чөлөө ба нэрээ нууцлах эрх илт зөрчигдөх болов. Ялангуяа мэдээ, мэдээллийн цахим хуудсыг бүртгэж, шүүлтүүр хэрэглэж байгаа нь ИУЭТОУП-ын 19-р зүйлийг зөрчиж байна.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Харилцаа холбооны зохицуулах хорооны (ХХЗХ) “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага”-ын дагуу хэрэглэгчдийн хандалтын дундаж тоо нь нэг сарын туршид өдөрт 3000-аас давсан тохиолдолд тухайн цахим хуудас ХХЗХ-д бүртгүүлж, “...шүүлтүүр програм заавал ашиглах”-ыг үүрэг болгосон байдаг.

Шүүлтүүрийн <http://www.happywebs.mn> дэх программд кирилл 86, латинаар галигласан 22 нийт 108 хориотой үг багтдаг. Тухайлбал, хэрэв хэрэглэгч sex, terrorist гэсэн үгийг сэтгэгдэл бичихдээ хэрэглэвэл од (***) болон хувирна.

Засгийн газар 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай 01 тоот тогтоол, үүнд үндэслэн ХХЗХ “Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам” баталсан. Журмаар интернэтийн болон үүрэн телефоны үйлчилгээ эрхлэгч хувийн компаниудад хууль зөрчсөн гэх иргэдийг илрүүлэхэд төрийн байгууллагын хүсэлтээр туслах, тухайн этгээдийн талаарх мэдээлэл цуглуулах үүрэг ногдуулсан байна.

“Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийг Тагнуулын ерөнхий газрын тусламжтай боловсруулж, гүтгэн доромжилсон, садар самуунд уруу татсан, заналхийлсэн агуулга бүхий сэтгэгдэл бичсэн этгээдийг тодруулж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулахыг Хууль зүйн сайдад үүрэг болгожээ. Цахим хуудаст хэрэглэгчийн үүсгэсэн сэтгэгдэл дээр интернэт хаягийг (IP address) нийтэд ил харагдахуйц байрлуулдаг.

ХХЗХ нь өргөн нэвтрүүлэг, цахим хуудас, контент агрегатор, контент нийлүүлэх үйлчилгээ эрхлэгчдийн агуулгад хяналт тавьдаг. Мөн зохиогчийн эрхийн зөрчилд хяналт тавьдаг. Ингэхдээ Цагдаагийн Ерөнхий газар, Оюуны өмчийн газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар зэрэг эрх бүхий төрийн байгууллагын мэдэгдэл, захидалд үндэслэн үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааг зогсоох эрхийг ХХЗХ эдэлдэг бөгөөд энэ нь цензур болон ашиглагдаж байна.

ХХЗХ-ны хараат бус байдал хангагдаагүй нь цензурыг бодитой болгож байна.

ХХЗХ-ны дүрэм, журмууд ИУТЭОУП-ын 19-р зүйлд заасан “хязгаарлалтыг хуулиар тогтоох”, “зайлшгүй байх”, “хэм хэмжээндээ байх” зэрэг шалгуурт нийцдэггүй. Мөн ЗГ-ын 2010 оны 119-р тогтоолоор батлагдсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-д тусгагдсан “хуулиар тусгайлан олгогдсон хэм хэмжээнд нийцсэн байх”, “хуульд заагаагүй үүргийг шинээр бий болгож, хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх”, “хариуцлага хүлээлгэхгүй байх”, “нөлөөллийн үнэлгээ хийх” зэрэг шаардлагыг илт зөрчиж байна.

Сонгогдсон эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтнууд нэр төр гутаахтай холбоотой эрүүгийн хуулийн заалтыг сэтгүүлчдийн эсрэг цензур болгон ашиглаж байна.

Эрүүгийн хуулиар нэр төр гутаахтай холбоотой гэмт хэргийг өндөр хэмжээний мөнгөн дүнгээр торгох, зургаан сар хүртэл баривчлах, 2-5 жил хүртэл хугацаанд хорих ялаар шийтгэхээр хуульчилсан. Нэр төр гутаахтай холбоотой зүйл заалт, торгууль нь бүх шатны сонгуулийн хуульд мөн байдаг. Төрийн албан тушаалтнууд Эрүүгийн хуулийг мэдээлэгч (шүгэлдэгч), сэтгүүлчийн нууц эх сурвалжийг илчлэх, далайлган сүрдүүлэх зорилгоор ашиглаж байна.

2005-2012 онд буюу 8 жилийн хугацаанд нэр төр гутаахтай холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн 27 хэрэг л байсан бол 2013-2014 онд буюу сүүлийн хоёрхон жилд шүүхээр шийдвэрлэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн тоо 13-д хүрээд байна.

2014 оны 7-р сарын 3-ны өдөр amjilt.com цахим хуудас “Ерөнхий сайдын “Хаан жимс” амралтын газар Туул гол руу бохироо асгаж байна” гарчигтай гэрэл зургийн сурвалжлагыг байршуулсны маргааш нь ХХЗХ-ны албан тушаалтан эмэгтэй цахим хуудасны удирдлага руу утасдаж “Хаан жимс амралтын газрын гомдлын дагуу ярьж байна, мэдээллээ устга, залруулга хий, тэгэхгүй бол цагийн дараа хандалтыг хаана” гэж хэлснээс хойш гурван цагийн дараа Монгол Улсаас тус цахим хуудас руу хандах хандалтыг хаасан байна. Тус цахим хуудасны үйл ажиллагааг өдгөө хүртэл зогсоосон хэвээр байна.

2012 оноос хойш ХХЗХ зохиогчийн эрхийг зөрчсөн гэсэн үндэслэлээр 172 цахим хуудасны Монгол Улсаас хандах хандалтыг зогсоожээ. ХХЗХ нь эдгээр цахим хуудасны жагсаалтыг www.black-list.mn хуудсанд байрлуулсан.

ХХЗХ нь бүтцийн хувьд Засгийн газрын агентлаг болох Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын харьяа бөгөөд дарга, гишүүдийг Ерөнхий сайд томилж, чөлөөлж, ажлаа Засгийн газарт тайлагнадаг. Нийт долоон гишүүн нь бүгд төрийн байгууллагын төлөөлөл юм.

ХХЗХ-ны зохицуулалтын дүрэм, журмууд нь Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгддэггүй. Иймд хүчин төгөлдөр бус шийдвэрээр тусгай зөвшөөрөл цуцлах, цахим хуудсыг зогсоох зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

Чингэлтэй дүүргийн шүүх Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийн гомдлоор “Тэргүүн” сонины эрхлэгч болон тус сонины сэтгүүлчид 20 гаруй сая төгрөгийн торгуулийн ял ногдуулж, торгох ялаас зайлсхийвэл 3 жил хүртэл хугацаагаар хорих ялаар солихоор шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүх ялыг хэвээр баталж, Дээд Шүүх сонины эрхлэгчид ногдуулсан торгуулийн хэмжээг 7 сая гаруй төгрөг хүртэл бууруулж, сэтгүүлчид ногдуулсан 7 160 400 төгрөгийн торгуулийн хэмжээг хэвээр үлдээжээ.

2014 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Зам, тээврийн сайд А.Гансүхийн гомдлын дагуу жиргээч Ц.Батыг Эрүүгийн хуулийн 111.2-т заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон анхан шатны шүүхээр 3 сар, 10 хоногийн баривчлах ялаар шийтгэв. 2014 оны 9-р сарын 9-ний өдрийн давж заалдах шатны шүүх хурлын шийдвэрээр хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж, Ц.Батыг батлан даалтад гаргажээ.

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. Засгийн газрын 2013 оны 01 тоот тогтоолыг хүчингүй болгож, үзэл бодлыг хянах төрийн хяналтын системийг халах.
2. ХХЗХ-ны “нөхцөл, шаардлага”, дүрэм журмуудыг хүчингүй болгох.
3. ХХЗХ-ны хараат бус байдлыг бүрэн хангах, олон нийтийн оролцоо, хяналт бий болгох, ил тод байдлыг хангах, Хорооны тайлагнах тогтолцоо, гишүүдийг томилох, чөлөөлөх өнөөгийн зохицуулалтыг шинэчлэх.
4. Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тогтоохгүй байх, бүртгэл, шүүлтүүр хэрэглэх, тусгай зөвшөөрөл олгох явдлыг зогсоох.
5. Агуулгад тавих хязгаарлалтуудыг ИУТЭОУП-ын 19-р зүйлийн зарчимд нийцүүлэх, холбогдох хуулиудад өөрчлөлт оруулах.
6. Гүтгэлэг, доромжлолыг Эрүүгийн хуулиас халах санаачилгыг сайшаахын сацуу Засгийн газар үүндээ тууштай байж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэх улс төрийн хүсэл зориггоо харуулах, манлайлах.
7. Нэр төр гутаахтай холбоотой хэрэг маргааныг шийдвэрлэхдээ олон улсын хүний эрхийн хэм хэмжээг ашиглах, хуульч, шүүгч, өмгөөлөгч, прокурорын ИУТЭОУП-ын 19-р зүйл, НҮБ-ын Хүний эрхийн хорооны тайлбар болон олон улсын бусад хэм хэмжээний талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх.
8. Иргэдийн хувийн нууцыг хамгаалах, нэрээ нууцлах, нууц нэр ашиглах эрхийг баталгаажуулах.
9. Шүгэлдэгч, сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах зохицуулалттай болгох.

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улс «Жэндэрийн эрх тэгш байдлын тухай», «Гэрч хохирогчийг хамгаалах тухай» хуулиудыг баталж, жендэрийн шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг хуулиар хориглосон. Мөн «Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай» хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-д өргөн мэдүүлж, «Гэмт хэргийн тухай» хуулийн төсөлд ялгаварлан гадуурхсан үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор тусгаад байгаа зэргийг иргэний нийгмийн байгууллагууд сайшаан дэмжиж байна. Үүний зэрэгцээ Засгийн газар Үйл ажиллагааны төлөвлөгөөндөө ялгаварлан

гадуурхалттай тэмцэх механизмыг судлах, энэ асуудлаар хууль санаачлахаар тусгасан нь сайшаалтай. Мөн түүнчлэн 2008 оны УИХ-ын сонгуулиар 3 эмэгтэй гишүүн сонгогдсон бол 2012 оны сонгуулиар 11 эмэгтэй УИХ-д сонгогдсон нь шийдвэр гаргах дээд түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог бодитой нэмэгдүүлсэн ахиц юм. Хэдийгээр дээр дурьдсан дэвшилттэй алхмуудыг авч хэрэгжүүлж байгаа ч ялгаварлан гадуурхалт түгээмэл байсаар байна.

Иргэдийн хувьд дараах шинжээр ялгаварлагдсаар байна:

- Нас
- Хүйс
- Бэлгийн чиг баримжаа
- Хөгжлийн бэрхшээл
- Үзэл бодол
- Гадаад төрх байдал
- Нийгмийн гарал

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Монгол Улс ялгаварлан гадуурхалтын эсрэг бие даасан хуульгүй, хуулийн төсөл боловсруулах ажил ч эхлээгүй. Жендэрийн тэгш байдлын тухай хуулиар жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглосон ч хуулийн сурталчилгаа хангалттай бус. Бодит амьдрал дээр нас, хүйс, гадаад төрх байдлаар ялгаварлан гадуурхах явдал түгээмэл гардаг.

Ялгаварлан гадуурхалтын бодит хохирлыг тооцдоггүй, гомдол гаргах үр дүнтэй механизм байхгүй, одоогийн механизм үр нөлөө багатай. Хүний эрхийн чиглэлээр НҮБ-ын хүний эрхийн механизмаас өгсөн зөвлөмжүүдийг нэгдсэн бодлогоор төлөвлөдөггүй, төсөвгүй зэргээс хэрэгжих боломжгүй болж байна.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Хөдөлмөрийн зах зээл дээр шинээр нээгдэж байгаа хоёр ажлын байр тутмын нэг нь насаар, гурван ажлын байр тутмын нэг нь хүйсээр ялгаварлаж байна.

“Монголын мянганы сан”-д ажилладаг эмэгтэй 2013 онд Хүний эрхийн Үндэсний Комисс /ХЭҮК/-т хандан өөрийг нь ажлын байран дахь бэлгийн дарамтад оруулсан төслийн захирал Б-ийн эсрэг гомдол гаргасан байна. Шалгалтаар Б нь гурван удаагийн үйлдлээр тухайн эмэгтэйг бэлгийн дарамтанд оруулсан болохыг тогтоожээ. ХЭҮК-оос албан шаардлага хүргүүлж, үр дүнд нь 2013 оны 04 сард 13/81 тоот тушаал гарган төслийн захирал Б-д үндсэн цалинг гурван сарын хугацаатай 10 хувиар бууруулах хэмжээний хариуцлага л тооцсон байна.

Гүйцэтгэх засаглал, орон нутгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо мэдэгдэхүйц нэмэгдээгүй.

Охид эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, үл хайхрах байдал олон нийтийн дунд хэвээр байна. ЗГ-ын олон хүүхэд төрүүлэхийг дэмжих бодлогын үр дүнд төрөлт нэмэгдэж байгаа нь сайн талтай ч цэцэрлэг хүртээмжгүйн улмаас залуу эмэгтэйчүүд гэртээ сууж, ажил хөдөлмөр эрхлэх боломжгүй болж байна. Мөн хөдлөх, үл хөдлөх хөрөнгө бүртгүүлэхэд эрэгтэйн нэр дээр бүртгэх явдал нийтлэг байгаагаас эмэгтэйчүүдийн хөрөнгөө барьцаалан зээл авах, эдийн засгийн амьдралд оролцох боломжийг хаасаар байна.

Хөдөлмөрийн насны буюу нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоо 2013 онд 59,4% байсан бол 2014 онд 57.3% болж буурсан байна.

Сэлэнгэ аймгийн Зүүнхараа сумын иргэн Д хэлэхдээ “... би нөхрөөсөө салсан, 2 хүүхдээ ганцаараа өсгөх болсон, дээр нь миний нуруу өвддөг хуучтай. Нас маань 40 гарсан тул ажил олддоггүй, Дэлхийн Зөн олон улсын байгууллагын тусламжтайгаар тахиа, туулай тэжээж, амьжиргаагаа залгуулдаг. Өвөл болж байна, тахианы саравч барих гэсэн ч “барьцаагүй” гээд банкнаас зээл олддоггүй. Ганц байгаа хөрөнгө болох газар маань салсан нөхрийн нэр дээр бүртгэлтэй учир зээлийн барьцаанд тавих боломжгүй...”

Эмэгтэйчүүд зөвхөн биеэ үнэлдэг гэсэн сөрөг ойлголт нийгэмд тогтсон. Монгол Улсад биеэ үнэлэхийг хориглодог бөгөөд биеэ үнэлсэн этгээдэд л зөвхөн захиргааны хариуцлага хүлээлгэж байна.

Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 4.1-д “биеэ үнэлэхийг хориглоно”, 13.2.1-д “энэ хуулийн 4.1... зөрчсөн бол биеэ үнэлж олсон орлогыг нь хурааж, 14-30 хоногийн хугацаагаар баривчлах” гэж заасан.

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. Төрийн бодлогын тогтвортой байдлыг хангах хөгжлийн урт хугацааны бодлого, төлөвлөлттэй болох.
2. Одоо өргөн баригдаад байгаа “Гэр бүлийн тухай”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Гэмт хэргийн тухай” зэрэг өргөн барьсан хуулийн төслүүдийн хүний эрхийн нөхцөл байдлыг дээрдүүлсэн зохицуулалтыг дордуулахгүйгээр, яаралтай батлах.
3. Ойрын хугацаанд “Бүх төрлийн ялгаварлан гадуурхалттай тэмцэх тухай” бие даасан хуультай болох, ялгаварлан гадуурхагдсан тухай гомдол гаргах, эрхээ сэргээлгэх боломжтой, хүртээмжтэй механизмыг бий болгох, хуулийн төслийг боловсруулах явцад иргэдийн бодитой оролцоог хангах.
4. Бүх төрлийн ялгаварлан гадуурхалттай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төсөв санхүүжилтийг хангалттай төсөвлөх.
5. Охид, эмэгтэйчүүдийг ялгаварлах, дорд үзэх хандлагыг арилгах хүрээнд олон нийтэд чиглэсэн үр дүнтэй, тогтмол нөлөөллийн үйл ажиллагаа явуулах.
6. Иргэдийг үзэл бодлоор нь ялгаварлан ажлаас халах, ажилд авах үзэгдлийг халах, үүнийг “Төрийн албаны тухай” хуульд заан баталгаажуулах, хяналт тавьж хариуцлага тооцох.

УУЛ УУРХАЙ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНИЙ ЭРХ

Монгол улс «Азийн Сауди Араб» хэмээн алдаршиж, Молборлох зах зээлийн од, хөрөнгө оруулагчдын ашигийн бай болж, дэлхийн хамгийн өндөр ДНБ-ний өсөлттэй орон болох амлалттай ажиллаж ирсэн. Энэ явц нь газар зүйн байрилаараа өндөрлөг, хуурай бүс нутагт оридог, уур амьсгалын өөрчлөлтөд дэлхийн дунджаас 3 дахин илүү өртдөг эмзэг экосистемтэй оронд сөрөг нөлөөллөө үзүүлж эхлэв. Жилд 4 км хурдацтай цөлжиж, газрын гадаргын 70% нь эвдрэлд өртөж, нийт голын 16.6, булаг шандны 24.4, нуур цөөрмийн 31.5 нь ширгэсэн байна. Уул уурхайн хэрэглээгээр ус бохирдож, нөөц нь хурдацтай хомсдохын зэрэгцээ голуудын гольдрол өөрчлөх төслүүд боловсруулагдаж байна. Уурхайн салбар хурдацтай хөгжих эрх зүйн орчин бүрдүүлэх нэрээр хөрөнгө оруулалт, ашигт малтмал, бусад хууль тогтоомжийн уялдаа холбоо улам суларч, хэрэгжилт хяналтгүй болсноор байгаль орчин, агаар, ус бохирдож, улмаар

хүний үндсэн эрхүүд зөрчигдөхөд хүрч байна. Уурхай, түүний дэд бүтэц тэлэхийн хэрээр газар эзэмшил ба ашиглалтад өөрчлөлт орж мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал эзэмшлийн газраасаа шахагдан, улмаар хот рүү нүүх нүүдэл нэмэгдэж байна. Монгол улс Хүний эрхийн Түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, хүний эрхийн бусад конвенциуд, байгаль орчны Киотогийн протокол, Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн конвенц, Рамсарийн конвенц, Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенц, Биологийн төрөл зүйлийн тухай конвенциор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхгүй байна. Мянганы хөгжлийн зорилтын 7 а-д заасан «2015 он гэхэд газар нутгийнхаа 30%-ийг хамгаалалтад авах» амлалтаасаа ухарч, уул уурхайн салбарыг газрын ангилал харгалзахгүй тэлэх бодлого явуулж эхэллээ.

Зөрчигдөж буй эрхүүд:

- Эрүүл аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах
- Уламжлалт байгалийн нөөцөө ашиглах, усаар хангагдах
- Уламжлалт соёл өв сангаа хадгалах, хамгаалуулах, хойч үедээ өвлүүлэх
- Газар эзэмших, өмчтэй байх, аж ахуй эрхлэх
- Зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хохиролдоо зохих нөхөн олговор авах
- Дарамт, хүч хэрэглэх аюулаас ангид нөхцөлд эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулах эрх

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Улсын Их Хурал байгаль хамгаалах эрх зүйн орчинг доройтуулж, уул уурхайн салбарыг зохицуулах хуулиудыг хооронд нь зөрчилдүүлж, байгалийн нөөц ашиглах стандартын хэрэгжилт, хяналтыг сулруулсан хууль тогтоомж баталж, хариуцлага ба маргаан шийдвэрлэх асуудлыг орхигдуулсан. 2014 онд баталсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Ашигт малтмалын тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОНУ) тухай хуулийг тус тус зөрчиж БОНУ-г хийхгүй байх, эсхүл ашиглах зөвшөөрөл олгогдсоны дараа хийдэг зөрчил улам лавширч байна. Засгийн газраас тухайн нутгийн хүн амын уламжлалт байгалийн нөөц ашиглах боломж, мөн ундны цэвэр усаар хангагдах эрхийг нь хамгаалах талаар уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудад шаардлага тавих эрх зүйн орчин байхгүй байна.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Засгийн газар Гол усны эх бүрэлдэх хамгаалалттай бүс, ойн сан бүхий газар ашигт малтмал хайх, олборлохыг хориглох тухай хуулийг ("урт нэртэй" гэгдэх) хэрэгжүүлэх Улсын Дээд шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзаж, хуулийг хэрэгжүүлэх журмыг өөрчлөх төсөл УИХ-д өргөн барьсан. УИХ 2013 оны 9-р сарын 16-нд "Урт нэртэй" хуулийг өөрчилж А лицензийг сэргээх, стратегийн орд газраар бүртгэж ашиглалтад оруулах, шүүхийн шийдвэрээр хаасан уурхайг нээх зэрэг эрх зүйн зөрчилтэй шийдвэрүүд гаргаж байгаа нь Монгол Улсын Мянганы хөгжлийн Зорилт (МХЗ) 7-ийн 15-д заасан "Усны түвшин бууралтаас хамгаалах зорилгоор гол, горхины эх авах газрыг хамгаалах, нөхөн сэргээх" тухай амлалттай зөрчилдөж байна.

Иргэдийн Үндсэн Хуулиар баталгаажсан эрх зөрчигдвөл сэргээн эдлүүлдэг эрх мэдлийг Үндсэн Хуулийн Цэцэд олгох тухай НҮБ-ын зөвлөмжийг хүлээж аваагүй. Газар чөлөөлөх тухай хууль батлагдаагүй байхад Улаанбаатар хотын Иргэний төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор МУ-ын иргэний газар эзэмших, өмчлөх, амьжиргаа залгуулах аж ахуй эрхлэх, учруулсан хохиролд шударга нөхөн олговор авах, эрхээ сэргээлгэн эдлэх зэрэг эрхүүдийг ноцтой зөрчиж байна.

Заншлын хуулийн дагуу эзэмшиж байгаа малчны бэлчээр, өвөлжөө, хаваржаа, хадлангийн газрын эрхийг баталгаажуулах, зөрчигдсөн эзэмшлийн эрхийг сэргээх механизм байхгүй. Газраа алдсан, шахагдан гарсан иргэд мал маллагааны дэд бүтэцгүй, өвлүүлэх хөрөнгөгүй, нүүдлийн мал маллагааны соёлоо хойч үедээ өвлүүлэх боломжгүй болж, амьжиргааны эх үүсвэрээсээ салсны улмаас дотоодын дүрвэгсэд болж байна.

НҮБ-ын ХЭЗ-өөс МУ-д хандан гаргасан зөвлөмж, Бизнес ба Хүний эрх Ажлын хэсгийн “МУ дахь Уул уурхай ба Хүний эрх” чиглэлээр өгсөн зөвлөмжүүдийг холбогдох талуудад хүргэж, хэрэгжүүлэх ажил хийгдээгүй.

Байгаль орчноо хамгаалах, эрхийнхээ төлөө тэмцэгч хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлэх зөвлөмжүүдийг үл ойшоож, харин ч шийтгэх, залхаах ажиллагаа нэмэгдсээр байна. Иргэдийг газар нутгаас нь шахан гаргах, хүчээр нүүлгэх, хөөн зайлуулах зэргээр эрхийг нь зөрчсөөр байхад тэд энэ талаар шийдвэр гаргах үйл явцад оролцож чадахгүй байна.

Иргэдэд газар өмчлөх үйл ажиллагааг сайжруулах зорилгоор цахим хэлбэрээр өргөдөл хүлээж авч, газар олгох хөтөлбөр нь хоёр том дутагдалтай гэж иргэд шүүмжилж байна: 1) цахимаар өргөдлөө гаргахад шаардагдах компьютер, тоног төхөөрөмж, хурдтай интернет холболт хүн амын дийлэнх хэсэгт байхгүй; мөн 2) олгож байгаа газар нь дэд бүтэц, нийгмийн үйлчилгээнээс хол, хад чулуу ихтэй тул орон сууц барих эсвэл гэр бүлийн өөр хэрэгцээнд ашиглах боломж муутай.

ЗГ-ын #111 тоот тогтоолоор Ухаа худаг-Цагаан хадны хооронд төмөр зам тавих ажлыг 2 сард багтаан яаравчлан гүйцэтгэхээр заасан нь түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох шуурга дэгдээв. Өвөлжөө, бэлчээрийг төмөр замын трасс, түр зам гаргаж дайрахын зэрэгцээ компаниуд БОНУ, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийхгүй, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор, амьжиргааг нөхөн сэргээх хөтөлбөргүй, хохирлыг нөхөн төлөхгүйгээр ажиллаж байна.

НҮБ-ын конвенциуд, МХЗ-ууд зэрэг олон улсын хэмжээнд авсан үүрэг амлалтаасаа ухарч Сэлэнгэ, Орхон голуудын усыг боож ашиглах, урагш уурхай руу татах төлөвлөгөө нь хил дамнан сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй тул НҮБ-ын Дэлхийн Өвийн сангаас анхааруулга авахад хүргэсэн. Олон улсын Байгаль орчны Уитлей сангийн 2014 оны шагналтан, Хил хязгааргүй гол мөрөн сүлжээний зохицуулагч Е.А. Симоновыг 2014 оны 8-р сарын 12-нд хилээр гарахад нь “албадан гаргасан” тамга дарсан нь Дэлхийн банкны Уул уурхайн дэд бүтэцэд хөрөнгө оруулалтыг дэмжих төслөөс гол усыг урагш уурхайн хэрэгцээнд татах судалгааны тайлан авах гэж хөөцөлдсөнтэй холбоотой гэж үзэж байна. Түүнийг Замын-Үүдийн боомтоор гарахад нь өөрт хэлэлгүй “хар тамга” дарсан нь албадан гаргах үйлдлийг дур зоргоор хэрэглэдэг, хүний эрхийн төлөө тэмцэгчдийг дарамталдаг МУ-ын төрийн практикийн тод жишээ юм.

Уул усаа уурхайн сөрөг нөлөөллөөс хамгаалах тэмцлийг манлайлсан Олон улсын байгаль орчны Голдманы шагналтан Ц. Мөнхбаярыг 7 жилээр ялласан. Шүүхийн өмнөх болон шүүхээр хэрэг шийдвэрлэх бүх шатанд эдлүүлвэл зохих эрхүүдийг эдлүүлээгүйгээс гадна, Засгийн газраас нэр төрийг нь гутаах олон нийтийн кампанит ажил зохион байгуулах, өндөр хэмжээнд мэдэгдлүүд хийх зэргээр шүүхийн хараат бус ажиллагаанд нөлөөлсөн.

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. НҮБ-ын байгаль орчны конвенциудаар болон МХЗ-оор хүлээсэн бүх үүрэг, түүний дотор МХЗ 7-ийн 146-д заасан үүргийг хэрэгжүүлэх.
2. Байгаль орчны болон ашигт малтмалын салбарыг зохицуулах хуулиудын хийдлийг арилгах.
3. Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн эрх болох газар эзэмших, өмчлөх, амьжиргаа залгуулах өмч хөрөнгөтэй, бэлчээртэй байх эрхүүдийг хот хөдөөд нэгэн адил хамгаалах хууль батлах.
4. Үндсэн хуулийн цэцийг шинэчилж, иргэдийн үндсэн эрх зөрчигдсөн тохиолдолд сэргээн эдлүүлэх гомдлыг хүлээн авч шийвэрлэдэг болгох.
5. НҮБ-ын Бизнес ба Хүний Эрх Удирдах Зарчмуудыг хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.
6. Дэлхийн өв сангийн Хорооны цэвэр усны ай сав, усны нөөцийг хамгаалах талаар МУ-ын Засгийн газарт өгсөн (WNC-14/38, COM/16, хуудас 130, 7В 76) зөвлөмжийг хэрэгжүүлэх.
7. Зөвлөмжийг хэрэгжүүлэхдээ Олон улсын байгаль хамгаалах холбооны Дэлхийн өв сангийн Байгалийн үнэлгээний удирдамжийг хэрэгжүүлэх техникийн туслалцааг олон улсын хамтын нийгэмлэгээс хүсэх.
8. НҮБ-ын Дотоодын дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийг урьж а) бэлчээрээс хараат, нүүдэлч хүн амын уламжлалт байгалийн нөөц ашиглах эрхийг хамгаалах хуулийн зохицуулалтыг эрэлхийлэх; б) нүүдэлч ахуй соёлоо хадгалан үлдэх боломжийг хангасан малчдын амьжиргааг нөхөн сэргээх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх.
9. Хүний эрхийг хамгаалагчдыг хамгаалах, үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчин бүрдүүлэх.
10. Хөдөөгийн алслагдсан сумдад амьдардаг иргэдэд шүүхийн, шүүхийн бус болон эрх зүйн туслалцаа авах боломжийг бүрдүүлэх.
11. Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн Тусгай илтгэгчийг урьж МУ дах хүний эрхийн хамгаалагчдын нөхцөл байдалд дүгнэлт, зөвлөмж гаргуулах.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭРГИЙГ ШҮҮХЭЭР ШИЙДҮҮЛЭХ ЭРХ

Монгол улс нь эрдэс баялгийн нөөц ихтэй ба түүнд тулгуурласан эдийн засгийн өсөлтийг хангах бодлогыг төрөөс хэрэгжүүлдэг. Гэвч сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа уул уурхайн салбарыг даган түүний зохисгүй үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхийн зөрчлүүд ихээр гарах боллоо. Хүний эрх хөгжил төв (ХЭХТ) ТББ 2005 оноос эхлэн уул уурхайн үйл ажиллагааны улмаас байгаль орчин бохирдон

сүйтгэгдсэн, түүний улмаас орон нутгийн иргэдийн эрх ашиг зөрчигдсөн хэргүүд дээр орон нутгийн иргэд, төрийн захиргааг төлөөлөн нийтийн эрх ашгийг хамгаалах стратегийн өмгөөлөл хийж байна. Бид нийт 22 хэрэг дээр буюу 2010 оноос хойш 11 хэрэг дээр ажиллаж байна. Эдгээр тодорхой хэрэг дээр ажиллахад тулгамдаж байсан бэрхшээлүүд дээр үндэслэн энэхүү мэдээллийг бэлтгэлээ.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Орон нутгийн иргэд, ялангуяа малчин иргэд хууль зүйн туслалцаа авах, тэр дундаа байгаль орчны асуудлаар шүүхэд эрхээ хамгаалуулах боломж хязгаарлагдмал байна.

Нийтийн эрх ашгийг нэхэмжлэн хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй. Зөвхөн байгаль орчны чиглэлээр ажиллахаар дүрэмдээ заасан ТББ-д нэхэмжлэх эрх байдаг бөгөөд хүний эрх, нийтийн эрх ашгийн өмгөөллөөр мэргэшсэн ТББ-уудын нэхэмжлэх эрх нээгдээгүй байна.

Байгаль орчны хохирлыг нэхэмжлэхэд шүүхийн тэмдэгтийн хураамж өндөр тул нэхэмжлэл гаргагч ТББ түүнийг төлөх боломжгүй байдаг.

Байгаль орчны хэргүүдэд шинжээчдийн оролцоо зайлшгүй шаардагддаг ба ТББ-д шинжээчдийн зардлыг төлөх боломж байдаггүй. Харин шүүхэд энэ зардлыг гаргах эрх байдаг боловч гаргадаггүйгээс шинжээчийн дүгнэлт хүлээн хэрэг удааширдаг.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Монгол улс нийт 300 гаруй сумтай ч 29 сум буюу сум дундын шүүх байдгаас 21 нь аймгийн төв дээр ажилладаг байна. Захиргааны хэргийн анхан шатны 20 шүүх бүгд аймгийн төв дээр ажилладаг. Сумдад өмгөөлөгч байдаггүйгээс сумын төв дээр хууль зүйн туслалцаа авах боломжгүй.

ХЭХТ нь Хөвсгөл аймгийн Бүрэнхааны фосфоритын ордод хууль бусаар олгогдсон тусгай зөвшөөрлүүдийг цуцлуулахаар нэхэмжлэл гаргасан боловч “Байгаль орчныг хамгаалах” асуудал нь уг байгууллагын дүрмийн зорилгод багтаагүй тул нэхэмжлэх эрхгүй гэж шүүх үзсэн.

ХЭХТ-ийн ажилласан Дорнодын Баяндун, Архангай аймгийн Цэнхэр, Төв аймгийн Заамар сумын хэрэг дээр энэ нөхцөл байдал үүссэн.

Сүхбаатар аймагт хууль бусаар олгогдоод буй цөмийн энергийн тусгай зөвшөөрлийг цуцлуулах хэрэгт Нийслэлийн захиргааны хэргийн шүүх өөрийн санаачлагаар шинжээч томилсон хэдий ч тухайн шинжээчийн өмнөх хэрэг дээр ажилласан зардлыг олгоогүй тул шинжээч энэ хэрэгт ажиллахаас татгалзсан. Шүүх энэ хэрэг дээр шинжээчийг хүлээхээс өөр ямар ч арга хэмжээ авч чадалгүй 3 улирал өнгөрөөд байна.

Байгаль орчны хэргийг шүүхэд нэхэмжлэхэд ТББ-д санхүүгийн дарамт учирч байна. Үүнд:

- Нотлох баримт бүрдүүлэх зардал
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зардал

Нийтийн эрх ашгийг өмгөөлөх өмгөөлөгчийн үйл ажиллагааг дэмжих оновчтой бодлого, зохицуулалт байхгүй. Өмгөөлөгчийн хөлсийг нэхэмжлэл гаргасан ТББ төлөх шаардлага гардаг.

Шүүх байгаль орчны хэргийг шуурхай шийдвэрлэдэггүй. Шинжээчийн дүгнэлт гаргуулах, хариуцагчийг эрэн сурвалжлах, шүүхийн шийдвэр биелүүлэх явдал сунжирч хэрэг удааширдаг. Мөн баримт бичигт үзлэг хийнэ гэсэн нэрийдлээр хэргийг удаашруулж хүнд суртал гаргадаг.

Шүүх болон шүүгчид хараат бус ажиллах зарчмаа байгаль орчны хэргүүд дээр баримтлахгүй байна. 2005 оноос хойш ажилласан байгаль орчны 22 хэргийн шийдвэрт нэг ч хэрэг дээр төрийн албан хаагч, төрийн байгууллагад хариуцлага тооцсон заалт орж байгаагүй. Гэтэл эдгээр хэрэг бүгд төрийн байгууллага, албан тушаалтан хуулиа хэрэгжүүлээгүйгээс үүдэн гарсан.

Байгаль орчны хэрэг дээр шаардагдах дүгнэлт шинжилгээ хийх төрөөс хараат бус лаборатори, шинжээч байдаггүй.

Баянхонгор аймгийн Галуут суманд уул уурхайн компаниар байгаль орчны нөхөн сэргээлт хийлгүүлэх тухай шүүхийн шийдвэрийг албадан хэрэгжүүлэх шийдвэр гүйцэтгэлийн зардлыг төлөх боломжгүй байсан тул албадан хэрэгжүүлэх хүсэлт гаргаж чадаагүй. Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлээгүй хэвээр байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлд “Өмгөөлөгч багшлах, эрдэм шинжилгээний болон өмгөөллийн хуулийн этгээд, Хуульчдын холбоонд хамаарахаас бусад ажил, албан тушаалыг хавсран эрхлэхийг хориглоно” гэж заасан байдаг. Үүний улмаас өмгөөлөгч ТББ-д ажиллах боломжгүй болсон.

Шинэ журам гарснаар Байгаль орчны үнэлгээ хийдэг мэргэжлийн байгууллагуудыг шинжээчээр томилдог болсон. Гэхдээ ийм байгууллагуудын ажлын хөлс их өндөр байдаг тул төрийн албан хаагчийг албан үүргийнх нь хувьд үнэ төлбөргүй шинжээчээр томилуулах хэрэгтэй болдог. Энэ тохиолдолд ажлын цаг зав гаргах, томилолтын зардал батлуулах гэсээр уддаг.

Хөвсгөлийн Бүрэнхааны орд ашиглах лицензүүдийг 2013 онд Улсын дээд шүүхийн шийдвэрээр цуцалсан боловч жилийн дараа “шинээр илэрсэн нөхцөл байдал” гэх нэрээр Улсын дээд шүүх дахин хуралдаж анхан шатны шүүхэд хэргийг буцаасан.

Агаарын бохирдлоос үүдэлтэй иргэдийн эрүүл мэндийн хохирлыг нэхэмжлэх хэрэг дээр дүгнэлт гаргах эрдэмтэн олдоогүй.

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. Иргэдэд хүртээмжтэй хууль зүйн үйлчилгээг орон нутагт бий болгох, шүүхийн хүртээмжийг сайжруулах.
2. ТББ-дад нийтийн эрх ашгийг нэхэмжлэх эрх зүйн орчинг нэн даруй бий болгох.
3. Нийтийн эрх ашгийн хэргээс шүүхийн тэмдэгтийн хураамж авдаггүй байх, шүүх шинжээчийн зардлыг шуурхай гаргах, Шүүхийн шинжилгээний үндэсний төвд байгаль орчны шинжээчийн баг байгуулж ажиллуулах, нийтийн эрх ашгийн хэргийн өмгөөлөл, нотлох баримт бүрдүүлэхтэй холбоотой зардлыг төр хариуцах, хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх өмгөөлөгчдийн үйл ажиллагааг дэмжих, урамшуулах, Монголын өмгөөлөгчдийн дунд “про-боно” үйл ажиллагааг нэвтрүүлэх, дэмжих бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх зэргээр нийтийн эрх ашгийг шүүхэд нэхэмжлэн хамгаалах үйл ажиллагааг санхүүгийн болон бодлогын түвшинд цогц дэмжих, хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийг өмгөөлөгч төрийн бус байгууллагад ажиллах боломжтой байхаар өөрчлөн найруулах.
4. Байгаль орчны дагнасан шүүх байгуулж, байгаль орчны хэрэг дээр шинжээчийн дүгнэлт гаргуулах, хариуцагчийг эрэн сурвалжлах тухай шүүхийн шийдвэрийг шуурхай хэрэгжүүлэх, байгаль орчны хэрэг дээр ажиллах бие даасан, хараат бус шинжээчдийн баг байгуулж ажиллуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх.
5. Шүүгчийн томилгоо, шүүхийн шийдвэрийг улс төрийн хүчин, төрийн өндөр албан тушаалтнуудын нөлөөнөөс ангид байхад чиглэсэн шинэчлэлийг дэмжих, шүүх төрийн байгууллага, албан тушаалтнуудад хариуцлага тооцдог байх, шүүгчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг сайжруулах.
6. Эрдэмтэд, эрдэм шинжилгээний лабораторийн бие даасан үйл ажиллагааг хангах.
7. Шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг сайжруулж, байгаль орчин, нийтийн эрх ашгийн хэргийг шийдвэр гүйцэтгэлийн зардлаас чөлөөлөх буюу шийдвэр гүйцэтгэлд үйлчилж буй урамшууллын тогтолцоог шинэчлэх.

БИЧИЛ УУРХАЙ БА ХҮНИЙ ЭРХ

Монгол Улсад 1990-ээд онд бүх нийтийг хамарсан ядуурал нүүрэлсэн цаг үед мянга мянган хүмүүсийн орлого олох, амьжиргаагаа залгуулах нэг хэлбэр болон бичил уурхай үүссэн билээ. Бичил уурхайчдын ихэнх нь зуд турханы улмаас хотоо харлуулж, малаа алдсан малчид юм. Сүүлийн 10 жилийн хугацаанд бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах алхмуудыг авч эхэлсэн бөгөөд 2010 онд «Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай журам» –ыг ЗГ-ын 308 дугаар тогтоолоор баталсан нь бичил уурхайг албажуулах анхны эрх зүйн баримт бичиг болсон. Бичил уурхайчид 2014 онд л гэхэд 40

сая ам.доллартай тэнцэх алтыг Монгол Банкинд тушаасан нь нийт тушаагдсан алтны 16%-ийг эзэлж буй бөгөөд энэ нь тэдний эдийн засагт оруулж буй хувь нэмрийг харуулсан үзүүлэлт юм. Гэвч хувиараа ашигт малтмал олборлож буй хэдэн арван мянган иргэдээс ердөө 3000 нь үйл ажиллагаагаа албажуулж, хууль ёсоор ашигт малтмал олборлох газартай болсон. Тэдний дийлэнхийн хууль ёсоор бичил уурхай эрхлэх газар олж авах, үйл ажиллагаагаа албажуулах эрх нь хангагдаагүй хэвээр байна.

БИЧИЛ УУРХАЙЧДЫН ХУВЬД ДООРХ ЭРХҮҮД ТҮГЭЭМЭЛ ЗӨРЧИГДӨЖ БАЙНА:

- Эрүүл аюулгүй орчинд амьдрах
- Цэвэр усаар хангагдах
- Газар эзэмших
- Эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын үйлчилгээ хүртэх
- Хүрэлцээтэй амьжиргаатай байх
- Эрүү шүүлт, хэрцгий, хүнлэг бусаар харьцахаас хамгаалагдах
- Хуулийн өмнө эрх тэгш байх

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Хэдийгээр Ашигт малтмалын тухай хуульд бичил уурхайн зориулалтаар газар олгох талаар нэмэлт, өөрчлөлт оруулсан ч уурхайчид газар олж авахад хүндрэл учирсан хэвээр байна. Бичил уурхайчдад үйл ажиллагаагаа албан ёсоор явуулах газрын зөвшөөрөл олгогдохгүй байгаагаас хууль бусаар олборлолт хийхэд хүрдэг. Албан бус, баталгаагүй ажлын байр нь бичил уурхайчдыг аюулгүй ажиллагааны шаардлага хангаагүй, эрсдэлтэй нөхцөлд олборлолт явуулахад хүргэж байна.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Сүүлийн 2 жилийн хугацаанд бичил уурхайчдад огт газар олгогдоогүй.

Цагдаа нар хэрэглэж байгаа багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хууль бус үйл ажиллагаа явуулсан гэсэн үндэслэлээр хураан авдаг. Мөн түүнчлэн бичил уурхайчдын дунд уурхайн компанийн хамгаалалтын албаныхан болон цагдаа нарт зодуулсан, эрүүл мэнд, өмч хөрөнгөөрөө хохирсон баримт олон байна. Хэдийгээр хохирсон ч хууль бусаар үйл ажиллагаа явуулж байгаа тул чимээгүй өнгөрөх нь түгээмэл.

2011 онд Заамар сумын тусгай зөвшөөрөл бүхий алтны уурхайн талбай руу зөвшөөрөлгүй дайрч орсон хувиараа ашигт малтмал олборлогчдын эсрэг хүч хэрэглэх үеэр 2 хүн амь насаа алдсан.

2007 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын химийн хорт болон аюултай бодисын хэрэглээний талаар явуулсан шалгалтаар нийт 120 газарт 53.3 га газрын 203508,8 м³ хөрс химийн хорт бодисоор хордсон гэсэн дүн гарч, уурхайчдын хэрэглэж байсан 147 тээрмийг хураан авч, уул уурхайн салбарт мөнгөн усны хэрэглээг 2008 оноос эхлэн хориглосон. Тиймээс 2009 онд мөнгөн усгүй баяжуулах технологийг нэвтрүүлж, нийт 4 цехийг байгуулсан байна. Гэвч Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг холбогдох яам баталж өгөхгүй байгаагаас шалтгаалан эдгээр цех өнөөг хүртэл ажиллаагүй.

Газар доор эсхүл аюултай багаж, тоног төхөөрөмжтэй ажиллах, хүнд ачаа тээвэрлэх, химийн аюултай бодистой харьцахад хүргэх ажлыг хүүхэд хийх нь аюултай тиймээс бичил уурхайгаас ашигт малтмал олборлох журамд хүүхдийн хөдөлмөрийг хориглосон.

Мөнгөн усны хэрэглээ “саарал орчин”-д орж, уурхайчид гэртээ нууцаар уур нүдүүр ашиглан мөнгөн ус хэрэглэж байна. Энэ нь уурхайчдыг төдийгүй гэр бүлийн бусад гишүүдийг мөнгөн уснаас хордоход хүргэсэн.

Өнөөдөр нийт 9 суманд бичил уурхайчид мөнгөн ус ашиглан алт гарган авсаар байна.

Хөдөө орон нутгийн эрүүл мэндийн ажилтнууд мөнгөн усны хордлогоос урьдчилан сэргийлэх, шинж тэмдгийг илрүүлэх, оношлох, эмчлэх чадавхигүй.

Өнөөдөр бичил уурхайн салбарт олон хүүхэд эцэг эхдээ туслах зорилгоор ажиллаж байна.

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. Монголд бичил уурхайчдын тоо цөөн биш гэдгийг хүлээн зөвшөөрч, Минаматагийн конвенцийг соёрхон батлах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах.
2. Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23 дугаар зүйлийг бичил уурхайчдын уурхай эрхлэх эрхийг хангах, тэдний үйл ажиллагааг албажуулахын тулд “сонгосон газар нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцсан эсэхийг тогтоох” гэж өөрчлөн найруулах.
3. Ашигт малтмалын тухай хуульд а) ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрийн тусгай зөвшөөрлийн талбайн зарим хэсгийг бичил уурхайчдад үнэ төлбөргүй ашиглуулах эсхүл бичил уурхайтай гурван талт гэрээ байгуулан ажиллах, б) орон нутгийн засаг захиргааны байгууллагад өмнө нь ашигласан, орхигдсон орд дээр бичил уурхайн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох эрх мэдлийг өгөх.
4. Ашигт малтмалын тухай хуульд бичил уурхайн асуудлаар Засгийн газрын болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох нэмэлт, өөрчлөлт оруулах.
5. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэний орлогын албан татварын тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд бичил уурхайчдын орлогын албан татварыг сард 53,000 төгрөг байхаар тогтоосныг бусадтай адилтган бууруулах.
6. Холбогдох яамд, агентлагууд бичил уурхайн чиглэлээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх үүднээс салбар хоорондын зохицуулалтын Үндэсний хороог байгуулах.
7. Мөнгөн усгүй технологийг нэвтрүүлэх, зөвшөөрөх замаар бичил уурхайн салбарын мөнгөн усны хэрэглээг шийдэх талаар шийдвэртэй арга хэмжээ авах.
8. Бичил уурхайн салбар дахь мөнгөн усны хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, асуудлыг шийдвэрлэх Эрүүл мэндийн стратеги боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг гаргах.
9. Бичил уурхайн салбар дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг шийдэх үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх.
10. Бичил уурхайгаар олборлосон алтыг орон нутгийн түвшинд худалдан борлуулах боломж бүрдүүлэх, бичил уурхайн алтны худалдааг зохицуулах журам боловсруулж, батлуулах.

ХДХВ, ДОХ-ТОЙ ХҮМҮҮСИЙН ЭСРЭГ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ



Монгол Улс 2011 онд батлагдсан Эрүүл мэндийн тухай хууль, 2012 онд батлагдсан Хүний дархлал хомсдлын вирус (ХДХВ) халдвар, дархлалын олдмол хомсдлоос (ДОХ) сэргийлэх тухай хуулиар хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр үзүүлэх бодлогыг тодорхойлж, шинээр боловсруулж буй Гэмт хэргийн тухай, Хөдөлмөрийн тухай хуулийн төслүүдэд ялгаварлан гадуурхалтыг хориглосон дэвшилттэй зохицуулалтыг тусгасан

зэрэг сайшаалтай алхмууд хийж байгаа ч хуулийн хэрэгжилт хангалтгүй, энэхүү асуудлыг хариуцах Үндэсний хороо одоог хүртэл байгуулагдаагүй. Мөн ХДХВ, ДОХ-ын халдвартай хүмүүсийн эрхийг хангах, хамгаалах чиглэлээр бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн албан тушаалтнуудын мэдлэг, хандлага сул, мэдээлэл хангалтгүй, тогтвор суурьшилтай ажилладаггүй зэрэг нийтлэг дутагдал байна.

ХДХВ, ДОХ-той хүмүүсийн хувьд дараах эрх нийтлэг зөрчигдөж байна:

- Ялгаварлан гадуурхалтаас ангид байх
- Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах
- Хувийн нууцаа хамгаалуулах
- Хөдөлмөрлөх
- Шударга шүүхээр шүүлгэх

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Монгол Улсад ялгаварлан гадуурхалтын эсрэг тусгайлсан хууль байхгүй. ХДХВ, ДОХ-той амьдарч буй хүмүүс ил болон далд хэлбэрээр ялгаварлан гадуурхалтад өртөх явдал түгээмэл байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т ялгаварлан гадуурхахыг хориглосон үндэслэлд эрүүл мэндээр нь ялгаварлан гадуурхахыг хориглоогүй тул ХДХВ-ийн халдвартай хүн ялгаварлан гадуурхагдахгүй байх эрх зүйн орчин бүрдээгүй. Үүний улмаас ХДХВ, ДОХ-той хүнийг ялгаварласан дүрэм, журам батлах тохиолдол гарсаар байна. Мөн түүнчлэн ХДХВ-ын шинжилгээ заавал хийлгэсэн байхыг шаардах нь түгээмэл. Тухайлбал, шинээр ажилд орох, нийтийн усан бассейнаар үйлчлүүлэх, мэс засалд орох зэрэгт ХДХВ-ийн шинжилгээ шаарддаг практик байна.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

“Хүний дархлал хомсдлын вирус халдвар, дархлалын олдмол хомсдлоос сэргийлэх тухай хууль”-ийн 11.5-д “ХДХВ-ын халдвар авсан, ДОХ-той нь тогтоогдсон хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хэмжээг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 30 дугаар зүйл болон энэ хуулийн 5.1.5-д заасны дагуу тодорхойлно.” гэсэн нь хөдөлмөр эрхлэх боломжоор нь ялгаварлан гадуурхсан шинжтэй байна.

Монгол Улс ХДХВ-ын халдвар тараахыг гэмт хэрэгт тооцож, ял шийтгэл оногдуулах зарчмыг баримталж байна. Одоо мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн 105.3, шинээр боловсруулж буй Гэмт хэргийн тухай хуулийн төслийн 15.6-д үүнийг гэмт хэрэгт тооцож, оногдуулах ял шийтгэлийг заасан.

Иргэн Д-ийн ажил дээр эмч нар ХДХВ-ын шинжилгээ авахаар ирэхэд, халдвартай гэдгийг нь мэдчихээд хамт олны зүгээс гадуурхах хандлага гаргана гэж айсандаа ажлаасаа гарчээ.

ХДХВ, ДОХ-той хүмүүсийн хувьд эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрх зөрчигдөх нь түгээмэл байна.

ХДХВ-ын халдвартай иргэн Б хувиараа жижиг мужааны ажил хийж, амьжиргаагаа залгуулдаг. Тэрээр ажлын багажинд хуруугаа тасалчихаад тусламж авахаар гэмтлийн эмнэлэгт очтол ДОХ-ын эмч байхгүй гэсэн шалтгаанаар 2 цаг гаруй эмнэлгийн тусламж үзүүлэлгүй хүлээлгэжээ. Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/-өөс ДОХ-ын эмч ирсний дараа л оёдол тавьж, боолт хийсэн байна.

ХДХВ-ийн халдвартай жирэмсэн эхчүүдийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар ХӨСҮТ дээр, орон нутагт бол ХӨСҮТ-ийн ДОХ-ын мэргэжилтнүүдийн хяналтан дор төрүүлдэг.

Хувийн нууцаа хамгаалуулах, амьд явах, шударга шүүхээр шүүлгэх эрх нь зөрчигдөж байна.

“ХДХВ, ДОХ-ын халдвартай амьдарч буй ЭБЭ-чүүдийн хүний эрхийн төлөв байдал” судалгаанд оролцогчдын 45% нь ХДХВ-ын халдвартай холбоотой хувь хүний эрүүл мэндийн нууц алдагдаж байсан гэж хариулсан.

2010 онд иргэн Э-ийн амь насыг хэрцгийгээр хөнөөсөн хэрэг гарсан бөгөөд шүүхээс хэрэгтэнд хөнгөн ял оногдуулсан. Хохирогчийн гэр бүлийн хүн давж заалдах хүсэлтэй байсан ч хохирогч Э-ийн ХДХВ-ийн халдвартай байсныг хамаатан, ах дүү нар нь мэдэх вий гэдгээс эмээж давж заалдаагүй орхисон.

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. Эрүүл мэндийн яам ХДХВ, ДОХ-ын халдвартай хүмүүсийг ялгаварлан гадуурхсан бодлого, шийдвэрээ эргэн харж, хүчингүй болгох.
2. ХДХВ, ДОХ-ын асуудлаарх эрх зүйн баримт бичгийг шинэчлэх, энэ чиглэлээрх бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, түүний үр дүнгийн үнэлгээ хийх явцад халдвартай амьдарч байгаа хүмүүсийн бодитой оролцоог хангах арга хэмжээ авах.
3. ХДХВ, ДОХ-ын асуудлаар хэрэгжүүлж буй бодлого, хөтөлбөрийн талаар хэвлэл мэдээллээр нээлттэй мэдээлэх, нийгмийн хандлагыг ялгаварлан гадуурхалтаас ангид байхад анхаарах.
4. ХДХВ, ДОХ-ын халдвартай амьдарч байгаа хүмүүсийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх, ялгаварлан гадуурхагдсан тохиолдолд эрхээ сэргээлгэх боломжтой эрх зүйн орчинг нэн даруй бүрдүүлэх.
5. ДОХ-ын Үндэсний хороог яаралтай байгуулж орон нутагт салбар зөвлөлүүд бий болгох.
6. ХДХВ, ДОХ-оос сэргийлэх ажлыг гадны тусламжаар хийдгийг зогсоож, төрөөс санхүүжүүлэх.
7. ХДХВ-ын халдвартай амьдарч буй хүмүүс ялгаварлан гадуурхагдахгүйгээр хөдөлмөр эрхлэх нөхцлийг бүрдүүлэх, эрх зүйн орчинг бий болгох.
8. ХДХВ, ДОХ-д өртөх эрсдэлт бүлэг болох бэлгийн цөөнхийн давхар ялгаварлан гадуурхалтыг бууруулах арга хэмжээ авах.
9. ХДХВ, ДОХ-д өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өндөр эрсдэлт бүлэгтэй ажилладаг ТББ-уудыг төрөөс дэмжих.
10. Улсын мэргэжлийн хяналтын байгууллага холбогдох хуулиудын хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавих.

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ӨЗГӨЖИЛТ ДҮГНЭЛТ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (UPR – UNIVERSAL PERIODIC REVIEW)
МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮМҮҮСИЙН ЭРХ

Монгол Улс Ази-Номхон Далайн Бүсийн Инчоны Стратегийг албан ёсоор хүлээн авч, «Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль»-ийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс (ХБХ гэх)-ийн оролцоотойгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц /ХБХЭК/-ийн зарчимд нийцүүлэн өөрчлөхөөр ажиллаж байгаа,

«ХБХЭК-ийг 2013-2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө» –г анх удаа баталсан зэрэг ахиц байна. Хэдийгээр дээр дурьдсан дэвшилттэй алхмууд хийгдсэн ч хуулийн хэрэгжилт хангалтгүй, үр дүн тогтвортой биш байгаагаас ихэнх зохицуулалт цаасан дээр л үлдэх хандлага зонхилж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд нийтлэг зөрчигдөж байгаа эрхүүд:

- Ялгаварлан гадуурхалтаас ангид байх
- Эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах
- Бие даан хараат бусаар амьдрах
- Чөлөөтэй зорчих
- Сурч боловсрох
- Мэдээлэл хайх, хүлээн авах
- Хөдөлмөрлөх
- Шударга шүүхээр шүүлгэх

ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ

Монгол Улсын хууль тогтоомжийг ХБХЭК-д нийцүүлэх, ХБХЭК-ийг шүүхэд эх сурвалж болгох үүднээс “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтлэх шаардлагатай байна. Мөн түүнчлэн ХБХ-ийн эрхийг баталгаажуулсан зохицуулалт салбар хоорондын уялдаагүйгээс хэрэгжилт хангалтгүй.

Монгол Улсад ялгаварлан гадуурхалтын эсрэг тусгайлсан хууль байхгүй. Үндсэн хуулийн ялгаварлан гадуурхахыг хориглосон үндэслэлд хөгжлийн бэрхшээл, бие эрхтний согог гэж ороогүй. Үүний улмаас ялгаварлан гадуурхсан хууль, дүрэм батлагдан мөрдөгдөх нь түгээмэл байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлийг хөдөлмөрийн чадвар алдалтаар тогтоож байгаа нь тэднийг шууд ялгаварласан зохицуулалт юм.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Хөдөлмөрийн хуулийн ХБХ-ийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн квотыг хэрэгжүүлэх үүрэг Хөдөлмөрийн хэлтэст, хариуцлага тооцох үүрэг Мэргэжлийн хяналтын газарт байдаг бөгөөд эдгээр байгууллага хамтын ажиллагаагаа уялдуулдаггүй тул хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэхгүй байх нь түгээмэл байна.

“Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 111.7-д “...хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхлэх боломжтой ажил, мэргэжлийн жагсаалтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн батална” гэж заасан, мөн MNS 5012:2011 “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага” гэсэн стандартын 5.8 – д “... хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зөвхөн асран хамгаалах хүнтэй явахыг зөвшөөрнө” гэсэн нь ХБХ-ийн бие даан амьдрахыг үгүйсгэсэн, ялгаварлан гадуурхсан заалт юм.

Тэргэнцэртэй эмэгтэй Г-д эмч нь “Чи өөрөө тэргэнцэртэй учир аборт хийлгэ” хэмээн зөвлөжээ.

<p>Дэд бүтэц хүртээмжгүй байгаагийн улмаас ХБХ-ийн чөлөөтэй зорчих, сурч боловсрох, мэдээлэл хайх, хүлээн авах, эмнэлгийн тусламж авах эрхүүд түгээмэл зөрчигдөж байна. ХБХ-ийг нийтийн тээвэр, иргэний барилга байгууламжид зорчих боломжийг хангах стандарт батлагдсан ч хэрэгжүүлэх механизм маш сул, хариуцлага тооцох арга хэлбэр тодорхойгүй тул хэрэгжилт хангалтгүй байна.</p>	<p>Нийслэлийн төвийн дүүргийн зам дагуух хамгийн тохижилттой хэсгийн 26 байгууллагад үнэлгээ хийхэд 50% нь огт хүртээмжгүй, 27% нь стандарт бус налуу замтай, 15% нь налуу замтай ч дотроо олон шаттай, үлдсэн 8% нь боломжийн налуу замтай, дотроо шатгүй байсан ч бие засах газаргүй байв.</p> <p>Эмнэлэг ХБХ-т хүртээмжгүй байна. Улаанбаатарын бүх эмнэлгийн 52.2% машины зогсоолоос эмнэлэг хүрэх зам нь хүртээмжгүй, 18.2 хувь налуу замгүй, 69.1% стандарт бус налуу замтай, эмнэлгүүдийн 71.9% цахилгаан шатгүй, 94.7% ХБХ-т зориулсан бие засах газаргүй болох нь тогтоогджээ.</p> <p>Нийтийн тээврийн зогсоол, нийтийн тээвэр ХБХ-т хүртээмжгүй. Гэвч Улаанбаатарт ХБХ-ийг зорчуулсан гэж төсвөөс нийтийн тээврийн компанид нөхөн төлбөр өгдөг бөгөөд 2013 онд л гэхэд 5.5 тэрбум (3 сая ам.доллар) төгрөгийг олгожээ.</p> <p>“Монголын Үндэсний Олон Нийтийн ТВ”-ийн “Цагийн хүрд” мэдээг эс тооцвол сонсголын бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл хүлээн авах боломж хаалттай байна.</p>
--	--

<p>ХБХ-ийн хөдөлмөр эрхлэлт туйлын хангалтгүй, хөдөлмөрт бэлтгэх, дадлагажуулах бодлого нь ХБХ-ийг гар ажиллагаа зонхилдог, хөдөлмөр зарцуулалт ихтэй, өрсөлдөх чадвар сул бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд илүүтэй хөтөлж байна.</p> <p>ХБ-тэй хүүхдийг тусгай сургуульд түшиглэн боловсрол эзэмшүүлэх хандлага зонхилж байна. Бага, дунд боловсролын тухай хуулиар ердийн сургуулиуд ХБ-тэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэх нөхцлийг бүрдүүлэх үүрэг хүлээсэн ч дэд бүтэц хүртээмжгүй, багшлах боловсон хүчин дутмаг хэвээр байна.</p>	<p>15 ба түүнээс дээш насны ХБХ-ийн 19.9% нь л хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 41.7% нь хувиараа, 35.7% нь цалинтай ажиллагч, 20.1% нь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч байна.</p> <p>Төрөлхийн ХБ-тэй 2 хүн тутмын 1 нь л боловсрол эзэмшдэг. 2014 онд Улаанбаатарт амьдардаг тархины саажилттай 150 хүүхдийн дунд судалгаа хийхэд 65% нь боловсролын ямар нэг байгууллагад огт хамрагддаггүй, 23 % нь сургуульд хамрагддаг, 12 % нь цэцэрлэгт хамрагддаг гэсэн судалгаа гарсан.</p>
--	---

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

- ХБХ-т хамаарах бүх эрх зүйн баримт бичгийг ХБХЭК-ийн зарчим, агуулгад нийцүүлэн шинэчлэх, энэ үйл явцад тэдний оролцоог хангах, хөтөлбөр, төсөлд санхүүжилтийг хамт шийдэх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох.
- ХБХЭК-ийг “Төрийн мэдээлэл” сэтгүүлд нийтлэх.
- Ялгаварлан гадуурхалтын эсрэг үр дүнтэй эрх зүйн орчинг бүрдүүлэх.
- ХБХ-ийг “хөдөлмөрийн чадвар алдалт”-аар тогтоодог аргачлалыг халах.
- Салбар хоорондын асуудлыг зохицуулах бүтцийг Ерөнхий сайдын дэргэд байгуулах, бүх шатны Засаг даргын дэргэд ХБХ-ийн Зөвлөл ажиллуулах.
- Боловсрол, эрүүл мэндийн салбарын барилга байгууламжийн стандартыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгох.
- Сонсгол, хэл ярианы болон харааны бэрхшээлтэй хүмүүст мэдээллийг хүртээмжтэй хүлээн авах технологи бүрдүүлэх.
- ХБХ-ийг нийтийн тээврээр зорчих боломжийг бүрдүүлэх шат дараатай арга хэмжээ авах.
- ХБХ-ийг мэргэжил, дадлага олгох, хамт олны дунд хөдөлмөрлөхөд бэлтгэх ажлыг систем дэс дараалалтай, хооронд нь нягт уялдаатай зохион байгуулах.
- ХБХ-ийн хувиараа эрхлэх хөдөлмөрийн нэр төрлийг олон болгох, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх техник технологийг нэвтрүүлэх.
- ХБХ-ийг бие даан амьдрахад дэмжих хувийн туслах болон зөвлөх үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлэх эрх зүйн орчинг буй болгож, хэрэгжүүлэх.
- ХБХ-ийн ангиллыг шинэчлэн боловсруулж, хөгжлийн бэрхшээлдээ тохирсон нийгмийн халамжийн үйлчилгээ авах боломжийг бий болгох.
- ХБ-тэй хүүхэд залуучуудыг боловсрол эзэмших эрхээр хангахын тулд хамран сургалтын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх.
- Шинээр боловсруулах хамран сургалтын хөтөлбөрт ХБХ-ийн оролцоог хангах.
- Багш, сурган хүмүүжүүлэгчдийг ХБ-тэй хүүхэд, залуучуудтай ажиллах арга зүйд сургах, бэлтгэх.
- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх зорилго бүхий мэдээллийг бодлого, дэс дараалалтай явуулах.
- Төрийн бүх шатны алба хаагч нарт зориулсан ХБХ-ийн эрхийн тухай сургалтыг тогтмол явуулах. Сургалтад хамрагдсан хүмүүст нийгмийн үйлчилгээний байгууллагад ажиллах эрх олгох.
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нийгмийн асуудлыг тодорхойлох судалгааг үндэсний хэмжээнд хийх.
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн ялгаатай хэрэгцээг хүндэтгэн үзэж, тэдний чадвар нөөц, онцлогт тохирсон бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ авах.
- Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүхий л эрхийг хангах, оролцоог дэмжих, хамгаалах талаар үндэсний хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.
- ХБХ-ийн сонгох эрхийг хангах зорилгоор сонгуулийн байр, сурталчилгааны ажлын хүртээмжийг нэмэгдүүлсэн хуулийн заалтыг тодорхой болгож, хэрэгжилтийг тогтвортой хангах.
- ХБХ-ийг бүх шатны сонгуульд сонгогдох эрхийг баталгаажуулах түр тусгай арга хэмжээ авах.

ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ЭЭЛЖИТ ДҮГНЭЛТ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ (UPR - UNIVERSAL PERIODIC REVIEW)
МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

ХҮНСНИЙ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ МЭДЭЭЛЭЛ

Үндэсний статистикийн хорооны 2012 оны «Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа»-гаар Монгол Улсын нийт хүн амын 30 шахам хувь хоногийн хоолоор авах шаардлагатай илчлэг, шим тэжээлийн бодисыг авч чадахгүй ядуу нөхцөлд амьдарч байна. Инфляц, төгрөгийн ханишны сулрал зэргээс үүдэн хүнсний бүтээгдэхүүний үнэ байнга өсч, эмзэг

бүлгийн иргэдийн хүнс худалдан авах чадавхи буурч байгаагаас өлсгөлөнд нэрвэгдэх боллоо. Засгийн Газраас 2011 онд илгээсэн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт /ЭЗНСЭОУП/-ын хэрэгжилтийн 4-р тайланд эмзэг бүлгийнхэн хүний хоногт авах дундаж илчлэгээс даруй 33 хувиар бага илчлэгтэй хоол хэрэглэж байна гэж дүгнэжээ.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс хүнсний эрхийн талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг харуулах тоо, мэдээ албан эх сурвалжуудад хомс байна. Өлсгөлөнгөөс ангид байх эрхийн хэрэгжилтийг үнэлэх үндсэн үзүүлэлтүүд болох тоо баримт, статистик мэдээлэл олдоогүй тул 2010 оноос хойш байдал хэрхэн өөрчлөгдсөнийг мэдэх аргагүй юм.

2011 онд НҮБ-аас гаргасан “Дэлхийн өлсгөлөнгийн зураглал”-д Монгол Улсыг нийт хүн амын 20-34% нь хоол тэжээлийн дутагдалтай орнуудын бүлэгт оруулсан байна.

Төрөөс хүн амын өлсгөлөнгөөс ангид байх цөм эрхийг хангах алхмууд авч хэрэгжүүлж байгаа ч хүртээмжийн хувьд туйлын хангалтгүй байна.

Иргэдийн зохистой хоол хүнс хэрэглэх эрхийн хэрэгжилт болон чанар, эрсдэл, ариун цэвэр, савлагаа, хадгалалтын хугацаа зэрэгт тавих хяналт муу байна. Хүнсний бүтээгдэхүүн, түүний чанар, аюулгүй байдлын талаарх мэдээлэл нээлттэй бус, нээлттэй болсон мэдээллийн үнэн бодитой эсэхэд эргэлзээ төрөхөөр байна. Хүнс эвсэл ТББ-аас хараат бус лаборатори бий болгох зөвлөмжийг холбогдох байгууллагад удаа дараа өгч, шаардаж ирсэн ч энэ талаар арга хэмжээ авсангүй.

КЭЙС, БАРИМТ, ТАЙЛБАР

Засгийн Газраас 2013 онд гаргасан Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийн талаарх үндэсний 5 дахь илтгэлд ч 2010 оноос хойших тоо баримт байхгүй байна.

Хүнс эвсэл ТББ-аас 2014 оны 2-р сард Нийслэлийн 6 дүүргийн захын гэр хорооллын 42 айлыг санамсаргүй түүврийн аргаар сонгож судлахад, 96% нь хүнсний ногоо тогтмол идэж чаддаггүй, 85% нь мах, гурил л хүнсэндээ хэрэглэдэг гэжээ. Эдгээр өрхийн 60% нь өдөрт өрхийн хоолондоо 3 доллар хүрэхгүй мөнгө зарцуулдаг бөгөөд бүгд хүнсээ зээлээр авдаг, зээлийн өртэй ажээ.

16,822 өрхийн 113,187 хүнд сар бүр (насанд хүрсэн хүнд 10000 төгрөг буюу 6 ам доллар, хүүхдэд 5000 төгрөг буюу 3 ам доллар) хүнсний талон өгч байна. Энэ нь ядуу хүн амын дөнгөж 6,5 хувийг л хамарч байгаа юм.

2014 оны эхээр Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль (ЭМШУИС гэх)-ийн лаборатори хүнсний ногоонд пестицид зөвшөөрөгдсөн хэмжээнээс илүү байгаа тухай нийтэд мэдээлсэн. Гэтэл үүнийг төрийн байгууллагын лаборатори үгүйсгэж, ЭМШУИС-ийн лабораторийн үйл ажиллагааг хязгаарлаж, шинжилгээ хийх, дүнг нийтэд тараахыг хориглосон.

Иргэд хүнсээ худалдан авах чадавхитай байх асуудал хөдөлмөрлөх эрхтэй зайлшгүй холбогдоно. Гэвч хөдөлмөрийн гэрээ байгуулах, түүнийг хэрэгжүүлэхийг шаардах эрх нь баталгааждаггүй тул иргэд хөдөлмөрөө мөлжүүлэх нь хэвийн үзэгдэл болж байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуулиар ажилчдын эрхийг хангалттай баталгаажуулаагүй, үйлдвэрчний эвлэлийн байгууллага байгуулах эрхийг зөрчихгүй байхыг ажил олгогчдод үүрэг болгоогүй тул олон ажилчидтай том уул уурхайн компани ч ажилчдын эрхийг зөрчих нь түгээмэл тохиолдож байна.

2012 онд Уул уурхайн “Өмнийн говийн элс” ХХК-ний ажилчид Үйлдвэрчний эвлэл байгуулж хөдөлмөрийн нөхцлөө сайжруулах, хуулийн дагуу амрах, ажиллах эрхээ хэрэгжүүлэхийг удаа дараа шаардаж, улмаар ажил хаяснаас болж 45 хүн ажлаас халагдсан.

2014 онд уул уурхайн Рио Тинто компанийн Оюутолгой төслийн 300 ажилчдыг нэгэн зэрэг гэнэт халсан. Үүнтэй холбогдуулан эрх ашгаа хамгаалж тэмцэх ямар ч үйлдэл ажилчдын зүгээс гаргаагүй.

2012 онд Хүний эрх хөгжил төв ТББ-ын Улаанбаатар хотын Яармаг дахь Мөнгөн хуримтлалын бүлэг хөдөлмөр эрхэлж байгаа 100 гишүүнээ оролцуулан судалгаа авахад 25% нь хөдөлмөрийн гэрээгүй, гэрээ хийсэн хүмүүсийн 50% нь “ажил олгогч хөдөлмөрийн гэрээг хэрэгжүүлдэггүй” гэж хариулсан байна.

МОНГОЛЫН ХҮНИЙ ЭРХИЙН ТББ-УУДЫН ФОРУМААС ДАРААХ ЗӨВЛӨМЖИЙГ САНАЛ БОЛГОЖ БАЙНА:

1. Ядуу, эмзэг бүлгийн иргэдийн хүнсний хэрэглээнд үнэлгээ хийж, тэдний өлсгөлөнгөөс ангид байх эрхийг баталгаажуулах. Хүнсний талон тараах хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх.
2. Эмзэг бүлгийн хүүхдэд зориулсан хүнсний хөтөлбөр нь хүүхдийн хүнсний бүтээгдэхүүнээр авах хоногийн илчлэг, шимт бодисын физиологийн нормын хэдэн хувийг хангаж байгааг тодорхойлох. Хүүхдийн хүнс, тэжээлийн дутагдлыг арилгах бусад арга хэмжээтэй уялдуулах.
3. Хүн амын хоол тэжээлийн дутагдлыг арилгах бодитой арга хэмжээ авах, үр дүнг харуулах тоон мэдээллийг тогтмол гаргах.
4. ЕБС-ийн бага ангийн сурагчдад “Үдийн цай хөтөлбөр”-ийн хүрээнд өгч буй хүнсний бүтээгдэхүүний илчлэг, шимт бодисыг стандартад нийцүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах.
5. Хүнсний бүтээгдэхүүний үнийн судалгааг тогтмол хийж, бага орлоготой иргэд физиологийн шаардлагатай хүнсээ хэрэглэж чадаж байгаа эсэхийг үнэлдэг болох.
6. Хүнсний бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах, үүнд иргэд, ТББ-ын оролцоог хангах, тэдний чадавхийг бэхжүүлэх, санхүүжилт, эрх зүйн орчноор дэмжих.
7. Хүнсний бүтээгдэхүүний лабораторийн хүчин чадал, хүртээмжийг үнэлэх, тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн боловсон хүчин болон бусад хангамжийг сайжруулах.
8. Сургууль, эрдэм шинжилгээний лабораторид хүнсний бүтээгдэхүүн шинжлэх магадлан итгэмжлэл олгож, шинжилгээний дүнг олон нийтэд мэдээлэх эрхийг олгох.
9. Монголын үндэсний олон нийтийн радио телевиз иргэдэд зориулж хүнсний асуудлаар шинжлэх ухаанд суурилсан ойлголт, мэдлэг, бодит мэдээлэл түгээх тогтмол нэвтрүүлэгтэй болох.
10. Хөдөлмөрийн хөлсний тариф тогтоож, хэрэгжүүлэх.
11. Хувийн хэвшлийн салбарт хөдөлмөрийн гэрээ заавал байгуулдаг байх эрх зүйн зохицуулалт бий болгох.
12. Ажилчдын эрх ашгийг хамгаалах байгууллага байгуулах эрхийг зөрчихгүй байхыг ажил олгогчдод үүрэг болгосон заалтыг Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хуульд тусгах.
13. Албан бус салбарт хөдөлмөрийн мөлжлөг нэмэгдэх хандлагатай байгааг анхааралдаа авч гомдол хүлээн авч шийдвэрлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх.